



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,  
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2022.11.03 № 03/1617

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ГАЗРЫН ДАРГА Ж.НАРАНБОЛД ТАНАА**

Төр засгийн болон орон нутгийн бодлого шийдвэр, байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, дээд шатны байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийг хүргүүлж байна. Хэрэгжүүлэн ажиллахыг мэдэгдье.

Хавсралт 7. хуудастай.

ДАРГА

Н.ХОНГОРЗУЛ



D:\Ажил 2022\Албан бичиг

4408221288

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН БОДЛОГЫН  
БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ЯВЦЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

**2022 оны 10 сарын 14-ний өдөр**

**Сайншанд**

**Нэг. Хяналт шалгалтын зорилго**

Төр засгийн болон орон нутгийн бодлого шийдвэр, байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, дээд шатны байгууллагуудаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтэд хяналт шалгалт, үнэлгээ хийн, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

**Хоёр. Хяналт шалгалтын арга зүй**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Хүнс, хөдөө аж ахуйн газарт Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Ш.Алимаа ахлан, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Бямбацэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн А.Баттуяа нар ажиллаж, бодлогын баримт бичгийн хяналт, хэрэгжилт, байгууллагын болон нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, байгууллагын чиг үүргийн бусад үзүүлэлтүүд болон дээд шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт шалгалт хийв.

**Гурав. Хяналт шалгалтын үр дүн**

Ажлын удирдамжийг урьдчилан хүргүүлсэн тул 2022 оны 10 сарын 14-ний өдөр Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Наранболд болон Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн Э.Золжаргал болон бусад мэргэжилтнүүдэд ажлын чиглэлийг танилцуулж, хяналт шалгалт хийсэн болно.

**Дөрөв. Бодлогын баримт бичгүүдийг хяналтад авсан байдал**

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Бодлогын баримт бичгийн хавтас үүсгэсэн, хавтсанд 2018-2021 оныг хүртэлх бодлогын баримт бичгүүд байх боловч 2022 оноос хойш шинэчилсэн баяжуулалтыг хангалттай түвшинд хийгээгүй.

Улсын хэмжээний урт хугацааны бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050", дунд хугацааны бодлогын баримт бичиг "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр", Үндэсний болон төрөөс баримтлах бодлого болон орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох "Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "Аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа-2" 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Дорноговь аймгийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөө", "Дэд хөтөлбөрүүд" болон богино хугацааны бодлогын баримт бичиг болох "Дорноговь аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө" зэргээр хавтас үүсгэн баяжуулалт хийсэн боловч байгууллагын чиг үүрэгт хамаарах заалт, арга хэмжээг ялган хяналтад аваагүй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийн хавтас үүсгэсэн байх боловч цаг үеийн баяжуулалт дутуу байна.



Ажлын байран дээр байсан 6 ажилтнаас холбогдох бодлогын баримт бичгийн хяналтад авсан байдалд шалгалт хийхэд хангалтгүй байна. Салбарын хуулийг хяналтад авснаас өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлж ажиллах боломжтой заалт арга хэмжээг өөрийн болгон эзэнжүүлээгүй.

Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар 14 дэд болог зорилтот хөтөлбөр хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс "Жимс жимсгэнэ", "Хүнсний ногоо", "Монгол малчин" "Иргэн бүр саначлагч-Өрх бүр үйлдвэрлэгч" гэсэн 4 дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Эдгээр 4 хөтөлбөрөөс 3 нь 2022 онд дуусна. Тус агентлаг нь аймгийн ИТХ-аар 2018 онд батлагдсан аймгийн төлөвлөгөөг хяналтад авснаас өөрөөр тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодотгон, төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй байна.

#### **Тав. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн байдал**

Хүнс, хөдөө аж ахуйн газарт харьяалах салбарын хуулиас гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын тогтоол 22, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 8, Засгийн газрын албан даалгавар 3 зэрэг хуваарилагдсан байх ба тэдгээрийн жагсаалт байхгүй, хяналтад авсан эсэх нь тодорхойгүй байдалтай байна.

2022 оны хагас жилийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд тус байгууллагаас гүйцэтгэсэн гэх мэдээллүүдийг газар дээр нь шалгахад хангалттай гүйцэтгэсэн гэж үзэх боломжгүй байна. Тухайлбал Засгийн газрын 2020 оны 3 сарын 25-ны өдрийн 106 дугаар тогтоолд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг даалгасан хэм хэмжээг 100 хувь биелүүлсэн гэж тайлагнасан боловч ажилчдын баримт бичиг төрийн албан хэрэг хөтлөлтийн журамд нийцээгүй байна.

Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зөвхөн 9 сарын гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ гэх баримт бичгүүд бичгээр үйлдэгдсэн боловч бусад сарын хийгдсэн ажил байхгүй байна. Ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө бичгээр байх боловч огноогүй, түүнийг 2022 оных гэж үзэх боломжгүй, бусад нь цахимд байгаа гэх боловч дарга нь баталгаажуулсан эсэх нь тодорхойгүй. Мөн байгууллагын ажилчдын төрийн албан хаагчийн хувийн хэрэгтэй түүврийн байдлаар танилцахад төрийн албан хаагчийн анкетыг дутуу бөглөсөн байна.

#### **Зургаа. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд**

##### **Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж буй байдал**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаас 2014 онд "Дотоод хяналт хийх журам"-ыг баталсан. Гэвч журмын үндэслэл болж буй эрх зүйн хэм хэмжээнд нэмэлт, өөрчлөлт удаа дараа орсныг үл тоон дахин шинэчлэн батлаагүй байх тул тус агентлагийн дотоод хяналт хийх журам эрх зүйн хөгжлийн хувьд болон хэрэглээний хувьд хоцрогдолтой байна.

Байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө бичгээр болон цахим хэлбэрээр байгууллагын санд байхгүй. Байгууллагын дотоод хяналт-шинжилгээний мэргэжилтэн улирал тутамд дотоод хяналт шалгалтыг ажилчдадаа хийдэг гэх боловч 2022 оны 3 улирлын шалгалтын тайлан, үр дүн бичгээр болон цахим хэлбэрээр авагдаагүй, ажлаа хүлээж аваад жил гаруй болсон боловч бодлогын



баримт бичгийг хяналтад авах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдох хэлтэс нэгжид зөвлөмж чиглэл хүргүүлэх, тайлагналтыг хариуцах зэрэг чиг үүргээ хангалтгүй хийж гүйцэтгэсэн байна.

Байгууллагын хэмжээнд аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд нэвтрэх эрхтэй 3 ажилтантай. Үүнд дарга, хүний нөөцийн мэргэжилтэн, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн нар багтана. Цахимд санд ажилтны эрхээр нэвтрэх үзэхэд хэвийн ажиллагаатай байсан.

**Долоо. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ хийж буй байдал болон байгууллагын ил тод байдал, байгууллагын дотоод үйл ажиллагаа**

Байгууллагын үйл ажиллагаанд иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг 2022 оны 3 сар, 9 сард 2 удаа бичгээр авсан байх боловч түүнийг нэгтгэн судалгааны үр дүнг гаргаагүй байна.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг шалгахын тулд тус байгууллагын гадаа болон дотор байрлалтай 2 ханын самбар, байгууллагын албан ёсны цахим хуудаст үзлэг хийсэн. Самбаруудад мэдээллийг харагдах байдлын хувь стандартын дагуу байрлуулсан, санхүүгийн сарын тайлан сүүлийн үеийн байдлаар буюу 9 сарын тайланг мэдээлсэн, хүний нөөцийн мэдээлэл мөн тусгагдсан, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэдэд чиглэсэн мэдээлэл авагдсан байна. Байгууллагын албан ёсны цахим хуудас идэвхтэй үйл ажиллагаатай, сул орон тооны мэдээлэл зэргийг нийтэлсэн сайн талтай байна.

**Байгууллагын дотоод үйл ажиллагаа**

Хяналт-шинжилгээ хийх явцад ажлын байранд мэргэжилтнүүдийн харилцаа, асуулга ярилцлага зохион байгуулахад ажлын идэвхи, удирдлагын түвшинд арга зүйгээр хангадаггүй, ажлаа өөрчлөх, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байгаа талаар яригдсан тул байгууллагын 14 ажилтнаас сэтгэл ханамжийн судалгааг авсан. Судалгааг сонголттой 25 асуулга, санал хүсэлтээ бичих гэсэн бүтцээр авсан. Судалгааны үр дүнг ажлын тайлангийн 1 дүгээр хавсралтаар хавсаргав.

Бичгээр санал авах судалгаанд нийт 9 ажилтан саналаа тусгаснаас 4 ажилтан цалин хөлс нэмэгдүүлэх шаардлагатай, 6 ажилтан удирдлагын арга барил, хандлага хангалтгүй түвшинд байгаа тул сургалтанд хамруулах, арга хэмжээ тооцох гэх санал гаргасан байна.

**Найм. Өмнөх шалгалтын хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт ба дээд шатны байгууллагын удирдлагаас болон аймгийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт**

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Архив, бичиг хэргийн ажилтан Д.Долгорсүрэн 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс томилогдон ажиллаж байна.

Тус байгууллагад 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл ирсэн нийт 302 ирсэн, 212 явсан бичиг бүртгэгджээ.

Байгууллагад ирсэн албан бичгийг 7 хоног, сараар гарган удирдлага, албан хаагчдад хариу хүргүүлэх хугацаа ойртсон болон хоцроосон бичгийн талаар танилцуулж, тухай бүрд үнэлэлт дүгнэлт өгч ажиллаагүй байна.

Өөрөөр хэлбэл тухайн байгууллагын ирсэн, явсан албан бичгийн хяналт сул, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг чиглүүлэх, үүрэгжүүлэх болон албан хаагчийн тус бүрийн хариуцан гаргаж буй мэдээ, мэдээллийг эх сурвалжтай нь тулгаж үнэн бодитой байдлыг баталгаажуулдаггүй нь харагдаж байна.



Мөн дээд шатны байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан бичигт хэд хэдэн асуудлыг дурдан тус бүрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд болон хэсэгчлэн зохион байгуулахыг үүрэг болгосон байх хэдий ч тус байгууллага нь бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авахгүй буюу тухайн албан бичгийн хариу хүргүүлэхээр тогтоосон хугацаанд аль нь арай хялбархан бичиж (хааж) болохоор байгаа заалт хэрэгжүүлсэн болоод хааж байна.

Дээд шатны байгууллагад явуулж байгаа мэдээ, тайлан нь 14 сумаас ирүүлсэн албан бичиг, түүний нэгтлэгийн хамт архивын нэгж болж байх ёстой юм. Гэтэл судалгаа, мэдээлэл тус бүрээр гаргасан материал байгаагүй. Мөн албан бичиг, үүрэг чиглэлийг хэрэгжүүлээгүй сумдад ажил сайжруулах, анхааруулах чиглэлээр хариу арга хэмжээ аваагүй байгаа нь тухай салбарын ажил аймгийн хэмжээнд хэрэгжээгүй, гаргаж буй мэдээ, мэдээллийн үнэ бодит байдал эргэлзээтэй болгож байна.



Жишээ болгож дараах материалыг татан үзлээ.

Авилгатай тэмцэх газрын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 04/9100 тоот албан бичгээр орон нутагт зөвлөмж ирүүлсэн.

Уг зөвлөмжийг аймгийн Засаг даргын орлогч даргын 2022 оны 08 дугаар сарын 02/938 тоот албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, сумдын Засаг дарга нарт нутаг дэвсгэрийн хэмжээнд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж тайлагнахыг үүрэг болгосон.




Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сум тус бүрийн онцлог (тухайн сумын сангийн үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж)-ыг харгалзан зөвлөмжийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө бүхий үүрэг чиглэлийг хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг сум тус бүрээс нотлох баримтаар баталгаажуулан авч, нэгтгэн (дээд шатны байгууллагаас ирсэн бичиг, сумдад ХХААГ-аас явуулсан бичиг, 14 сумаас ирүүлсэн тайлан бүхий албан бичиг, ХХААГ-ын нэгтгэл, бусад зэрэг нь нийлээд архивын 1 нэгж болгох) үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай газруудад цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл, зөвлөгөө зөвлөмжийг хүргүүлэх байсан. Мөн дээрх зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, сум тус бүрийн ололттой болон дутагдалтай тал, цаашид хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргад танилцуулж, энэ чиглэлийн ажил нь тасралтгүй үргэлжлэн хэрэгжиж байх ёстой юм.

Гэтэл зөвлөмжид дурдсан заалт тус бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээг аваагүй байна.








Тус байгууллагаас явуулсан бичигт холбогдох стандарт зөрчсөн зөрчил дутагдал удаа дараа гаргасан байна. Жишээ нь:






Агентлагийн хэмжээнд болон хэсэгчлэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын шинжтэй үүрэг чиглэлийн заалт (тухайн бичигт дурдсан чиглэл тус бүр) нэг бүрийн хэрэгжилтийг хангаагүй, байгууллагын дотоодод багаар ажиллах, сумдыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах тал дээр хангалтгүй ажиллаж байна. Шалгалтын явцад татаж үзсэн материалд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаал, Дорноговь аймаг 2022 оныг “Хүүхдийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 210 тоот албан бичгээр байгууллага тус бүр хэрэгжүүлвэл зохих (5 багц асуудал бүхий) чиглэлийг хүргүүлсэн байна. Гэтэл албан бичигт дурдсан 5 асуудлаас 1 асуудлыг нь авч, Хүнс, хөдөө аж ахуйн газар даргын 2022 оын А/26 дугаар тушаал гарган хариу хүргүүлж, уг албан бичгийг хугацаанд нь хаасан.

Байгууллагын даргын тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг”-т албан хаагчид, тэдний гэр бүл, хүүхдэд чиглэсэн нийлээд олон ажлуудыг хийж гүйцэтгэхээр тусгасан боловч өнөөдрийг хүртэл зохион байгуулсан, хэрэгжүүлсэн ажил байхгүй. Тухайлбал: Байгууллагын дотоод журамд тодотгол хийгээгүй, “Эцэг эхийн зөвлөл” байгуулаагүй байна.







### Ес. Дүгнэлт, зөвлөмж

Хүнс, хөдөө аж ахуйн газрын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хяналт, хэрэгжилт, байгууллагын болон нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, явцын хяналт, гүйцэтгэлийн тайлагналтын чанар, төрийн ажлын зохион байгуулалт нь “Хангалтгүй түвшин”-д байх тул Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэгт заасан эрхийн дагуу тус журмын 12 дугаар зүйлийн 12.2.1, 12.2.2 дахь хэсэгт зохицуулсныг үндэслэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргад Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлагаас сонгон тооцох саналыг аймгийн Засаг даргад энэхүү дүгнэлт, зөвлөмжөөр хүргүүлж байна.

Хяналт шалгалт хийсэнтэй холбоотойгоор Хүнс, хөдөө аж ахуйн газарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Бодлогын баримт бичгүүдэд цаг үеийн баяжуулалтыг нэмэх;
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авахдаа ерөнхийлөх бус нарийвчлах арга зүйг ашиглах, эргэн хянах (Зөвхөн хууль, Засгийн газрын тогтоолоос гадна хуралдааны тэмдэглэл, албан даалгавар, зарлиг, захирамж байгааг анхаарах);
- Засгийн газрын 2020 оны 246 тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг байгууллагын хэмжээнд сурталчлах, чандлан мөрдөх;
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаартай тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг сурталчлах, чандлан мөрдөх;
- Байгууллагын дотоод хяналт хийх журмыг үндэслэл болж буй бусад эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн шинэчлэн баталж, дагаж мөрдөх;
- Хэрэглэгчээс сэтгэл ханамжийн судалгааг авсны дараа заавал судалгааны үр дүнг гаргах, мэдээлэх
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн тухайн байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө гарган ажиллах;
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалаар тус тус батлагдсан заавар, журамтай нийт албан хаагчид бүрэн танилцах, байгууллагын болон төрийн жинхэнэ



албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, зааврын дагуу боловсруулж, тайлагнах;

- Хариуцсан албан хаагчийг хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургаж, чадавхжуулах;
- Бодлогын баримт бичгүүдээс салбарт хамаарах заалт бүрийг нэг бүрчлэн хяналтад авч, улирал бүр хэрэгжилтийн явцыг гаргаж, байгууллагын дарга, албан хаагчдад танилцуулж хэвших;
- Байгууллагын албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан төлөвлөх, үнэн зөв тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх
- Байгууллагад дотоод хяналтыг журмын дагуу хэрэгжүүлэн ажиллах;
- Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн хэрэгжүүлэх нийтлэг үүрэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийт албан хаагчдад мөрдүүлэн ажиллуулах зэрэг болно.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Н.ХОНГОРЗУЛ

ТАЙЛАН БИЧСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ш.АЛИМАА

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, likely belonging to N. Byambatsyreg.

Н.БЯМБАЦЭЦЭГ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.Баттуяа

А.БАТТУЯА